

**ДОРНЫН АНАГААХ УХААНЫ ИХ ЭРДЭМТЭН П.А.БАДМАЕВ**

“Жүд ши” (Анагаах ухааны дөрвөн үндэс) хэмээх суурь бүтээлийг орос хэлнээ анх орчуулсан, дорно дахины судлаач, Оросын европын бүс нутагт Төвдийн анагаах ухааныг үндэслэгч, томоохон эрдэмтэн миний өвөг эцэг Петр Александрович Бадмаевын нэр олон жилийн турш мартагдсанаар үл барам энэ хүний талаар бүр санаатайгаар дуугарахгүй байжээ. Тэрбээр тухайн үеийнхээ нэрт эмчийн хувьд хааны гэр бүлийн гишүүдийг эмчилдэг байсан, генерал цолтой гэж буруутгагдаж байв. П.А.Бадмаевын эхнэр, миний эмэг ээж Е.Ф.Бадмаева нөхрийнхөө талаар үнэн мөнийг сэргээн тогтоох оролдлого хийж байжээ. Бүр 1950 онд тэрбээр Төвдийн анагаах ухааны системийг нээсэн түүний бүтээлийг хэвлүүлэх, П.А.Бадмаевын архивыг хүлээлгэн өгөх санал Эрүүлийг хамгаалах Яаманд тавьжээ. Ингээд эмэг эх маань хариугаа хүлээж чадалгүй 1954 онд өөд болов.

1960-аад онд миний ээж, П.А.Бадмаевын отгон охин, эмч, Лида Петровна Гусева мөн л өөрийнхөө бүтээлүүдийг хэвлүүлэх талаар Эрүүл мэндийн Яам, Анагаах ухааны Академид ханджээ. Хариулт тодорхойгүйгээр чимээ алджээ. Төвд эмийн жорыг хэвлүүлэх тухай, эмийн ургамалын салбарын томоохон эрдэмтэн, эм зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Ф. Гаморман өргөдөл гаргаж байсан ба энэ тухайгаа мэдээлэхдээ, А.П.Гусева өөрийн эм зүйн бүтээлүүдийг цэгцлэх талаар үлэмж их ажил гүйцэтгэсэн гэжээ. Гагцхүү энэ бүх хүсэлт ямарч хариугүй талаар өнгөрчээ.

Гэвч цаг хугацаа өөрчлөгдлөө. 1978 онд Монголын Шинжлэх Ухааны Академи “Эмийн ургамалууд” гэсэн ном анхлан хэвлүүлсэн нь тэр үедээ анхны алтан хараацай болов. Тэрхүү тулгуур бичигт “Жүд ши”-ийн орчуулагч П.А.Бадмаев, Ленинградын хими эм зүйн институтын “Эрдэм шинжилгээний бичиг” цувралуудад хэвлэгдсэн төвдийн анагаах ухааны тухай олон өгүүлэлийг зохиогч А.П.Гусева гэсэн хоёр хүний нэр дурьдагдсан юм. Энэхүү ном цөөн хувь /1000 ш/ боловч орос хэлээр хэвлэгдлээ.

1987 оны 12-р сард намайг “Петербург, Петроград, Ленинград дахь төвдийн Анагаах ухаан” гэсэн сэдэвт Анагаах ухааны түүхийн судалгааны нийгэмлэгийн хуралд урьсан юм. Анагаах ухааны түүхээр олон ном бичсэн биологийн шинжлэх ухааны дэд доктор илтгэгч Т.И.Грехова илтгэлийнхээ үндсэн хэсгийн Бадмаевд зориулсан байлаа. Энэ хурал дээр Петр Александрович Бадмаевын тухай олон хүн талархалын үг хэллээ.

“Генерал цолтой байсан хааны ордоны шадар хүн, тэрчилэн Каснугийнтай анд байсан /оросийн их зөнч. орч/ гэдэг шалтгаанаас болоод П.А.Бадмаевын аугаа их алдар гавъяаны талаар дуугарахгүй

иржээ. Гэвч олдсон бүх баримт аугаа их эрдэмт өвгөнийг даравч далдайх, булавч бултайхын гэрч баримт боллоо. Ингээд түүнийг элдвээр дайрагчдын оролдлого, амжилтгүй болж, эрдэмтний байр суурийг нь нотлож байна” гэсэн үгийг шинжлэх ухааны эрхэм дээд индэр дээрээс би анх удаагаа сонссон юм.

Энэ хуралдааны тухай мэдээ “Вечерный Ленинград” сонинд нийтлэгдэж билээ. Дараа нь “Известия” сонины ням гарагийн хавсралт “Неделя”-д, “Бадмаевын хааны домог ба үнэн” гэсэн том өгүүлэл өвөг эшгийн зурагтай хамт нийтлэгдсэн.

ЗСБНХУ-ын ШУА-ийн ажилтан профессор П.Б.Погожев, эрдэм шинжилгээний ахмад ажилтан Э.Ю.Кушниренко төрөл төрөгсөдийнх нь зөвшөөрлөөр П.А.Бадмаевын архивын материалын цэсийг гүйцэтгэх ажил хийжээ. Үүний дараа ЗСБНХУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч Г.И.Марчук, ЗСБНХУ-ын анагаах ухааны академич Бүгд Найрамдах Беларус улсын цацраг идэвхит Анагаах ухааны институтийн захирал В.А.Матюкин нар захиа илгээж, тэд нар П.А.Бадмаевыг төвдийн анагаах ухааныг нэвтэрхий мэдлэг хүн гээд түүний бүтээлүүдийг нийтлэх санал тавьцгаав. Ингээд би П.А.Бадмаевын архивд бүр 1975 оноос ажиллаж эхийгээ таалал төгссөний дараа түүний гэрээсийг биелүүлсэн юм. 1989 оны “Новый мир” сэтгүүлийн 11-р дугаарт “Миний өвөг Жамсран Бадмаев” гэсэн миний бичсэн баримтат тууж хэвлэгдлээ. Туужид редакцийн зүгээс бичсэн оршилд П.А.Бадмаевын бүтээлүүдийн өнөөгийн чухал асуудал хийгээд академич В.А.Матюхины үнэлгээг иш татсан байв. Төв телевиз өвөг эшгийн минь алдарыг сонирхож 30 минутын нэвтрүүлэг хийв. Энэ нэвтрүүлэг 1990 оны 3-р сарын 25-нд давтагдаж, бас 1990 оны 4-р сарын 25-ны “Медицинская газета” сонинд надтай хийсэн томоохон ярилцлагыг нийтлэв.

Миний өвөг эцэг уугуул Монгол хүн агаад Байгалын чанад нутгийн Агийн талд хонь, хурга хариулж өсчээ. Түүний нэрийг Жамсран гэдэг байсан. Тэрбээр дунд зэргийн чинээлэг Зосогол Бадмагийн 7-р буюу отгон хүү нь юм. Тэднийх зургаан ханатай гэрт сууж, Агийн талаар нүүдэллэн аж төрдөг байв. Энэ бол өнгөрсөн зууны цаг төрийн амар жимэр үе байлаа. Бадмагийн гэр бүл Агь болон Байгалын чанадад нэр хүндтэй айл байв.

Монголчуудын болон буриадуудын дунд өөрийн 11 удмыг мэдэж байх ёстой байв. Энэ уламжлал үе удам дамжсаар иржээ. Зосогол Бадма өөрийн удамыг Добу мэргэнээс эхлэн хөтөлжээ. Добу мэргэн бол Чингис хааны өвөг удам. Бадма гэдэг бол монголоор Бадамлянхуа цэцэг гэсэн үг. Чингис хаан ч хайртай охиноо Бадма гэдэг байжээ. Бас Бадмагийн гэр бүл том ах Чүлтэм нь Төвдийн анагаах ухааны

эмчлэх урлагаар алдаршсан, тал нутгийн домын эмч хүн байснаараа ч бас алдартай. Түүний нэр алдар Агь нутгийн гадна ч түгэн дэлгэрчээ.

Байгалын чанадад гэдэсний хижиг дэгдсэн үед Оросын эрх баригчид Төвдийн домч нараас тусламж хүсчээ. Хижигтэй тэмцэхэд Чүлтэм туслахуудынхаа хамт оролцжээ. Эмчилгээний амжилттай үр дүнд тэр үеийн дэвшилт зүтгэлтэн Дорнод сибирийн амбан захирагч, гүнтэн Муравьев Амурский ихэд гайхан биширчээ. Түүний саналаар Чүлтэмийг Петербургт урьж Николаевын цэргийн госпитальд туршилтаар томилж, хорт хавдар болон улаан бурхан мэтийн аюулт өвчнөөр өвдөж найдваргүйд тооцогдож байсан өвчтөнийг өөрийн эм тариагаараа эмчлэхийг даалгажээ. Энэ ажлын үр дүнгийн тухай баримт материалд өгүүлэхдээ: “А.А.Бадмаевагийн<sup>1</sup> эмчилгээний үр дүнг 1862 оны 1-р сарын 16-нд Бадмаевд олгосон Цэргийн яамны эмнэлгийн хэлтсийн эрхэм дээд өргөмжлөлөөр батлаж, түүнд цэргийн мундир зүрх эмчлэгч цол зэрэг шагнаан, цэргийн эмч зэрэг олгосоноор батлав” гэжээ. Александр Александрович Петербургд төвд эмийн ургамлын сан нээж, хувиараа ажиллав. Петербург явахын өмнө тэрбээр дүү Жамсрангаа Эрхүү хотын орос сонгодог гимназид суралцуулахыг хүссэн өргөдөл гаргаж байсан ба хүсэлтийг нь ёсоор болгожээ. Жамсран гимназийг алтан медальтай төгсчээ. Ах нь Жамсранг бусад дүү нарынхаа дундаас онцолдог байсан нь санамсаргүй зүйл байсангүй. Түүнийг ах нь асар их авъяастай гэж үздэг байв. Ингээд ах нь өөрийн туслагч цаашдын залгамжлагч болгох гэж эцэг эхээс нь Жамсранг Петербург явуулахыг хүсчээ. Агшин зуур юмыг сэтгэдэг, сониуч, ухаалаг гимназийн боловсролтой залуу Жамсран Петербургд иржээ. Удалгүй тэрбээр шинэ орчинд идээшин дасч Санктпетербургийн их сургуулийн Дорно дахины факультетэд элсэн орлоо. Жамсран маш их эрч хүчтэй, нийтэч залуу байв. Тэрбээр бүх юманд амжилттай суралцан үдэш нь ахаасаа төвдийн анагаах ухааны нууцыг сурдаг байв. Хазаарлаж болшгүй эрч хүчний энэхүү цэнэг, тэнгэр бурханы авъяасаа тэрбээр насан туршдаа тээж явлаа. Жаран нас хүртлээ өдөрт 16 цаг хөдөлмөрлөж, 70 настайдаа ч өдрийнхөө хөдөлмөрийг маш ухаалаг зохицуулна. 3-4 цаг ажиллаад 7-10 минут дугхийнэ. Иймээс түүний ухаан санаа ямагт хурц, сэргэлэн байдаг байв.

Тэрбээр Академид эчнээгээр шалгуулж, эмчлэх эрх оллоо. Европын анагаах ухааны мэдлэгтэй боловч өөрийгөө төвдийн анагаах ухаанд зориулахаар шийджээ. Ахынхаа үлгэр жишээгээр тэрбээр загалмайж, өөрийн шүтээн их Петрийн нэрийг авчээ. Эцэгээ Эзэн хааны

<sup>1</sup> Чүлтэм Петербургд ирээд загалмайлуулж, Үнэн алдартны шашинд орж Александр гэдэг шинэ нэртэй болж, эцгийнхээ нэрийг заншил ёсоор загалмайлан VI Александр эзэн хааны нэрээр нэрлэжээ /зохиолч/

нэрээр нэрлэв. Түүнийг загалмайлан эцэг нь Цесаревичийн удам залгамжлагч, ирээдүйн эзэн хаан III Александр болсон агаад өвөөгийн II Николайд бичсэн нэг захианд энэ талаар шууд дурдсан байв.

Их сургууль төгсөөд, Петрт Оросын эзэнт гүрний ГЯЯ анагаах ухааны дорно дахины институтын Азийн хэлтэст 8-р зэргийн албан тушаал олгохыг санал болгосноор тэрээр энэ албанд оров. Жамсран Төвдийн анагаах ухааныг судлах гол гарын авлага болох “Жүдши” номын 2 хуудас жинхэнэ гар бичмэл олох зорилготой байжээ. Ахынх нь хэлсэн гар бичмэл зүүнээс баруун тийш бус дээрээс дорнод унших агр бичмэл байжээ. Харамсалтай нь ах Александр /Чүлтэм/ 1873 онд идэр насандаа нас баржээ. Ингээд түүний эмийн сан, өвчтөнүүд Петрийн мэдэлд шилжив. Өвөг эцгийн энэ үеийн амьдрал тун бүдэг бадаг юм. Тэрбээр өөрийн хэлтсийн даалгавараар Хятад, Монголд явж оточ лам нар, төвдийн анагаах ухаан мэдэгчидтэй уулзан учирч тэднээс ихийг сурч мэджээ. Бадмагийн өвөг Чингис хааны удмын хүний нэгд тооцогдоно. Хятадад ирээд тэрбээр Манжийн эзэнт гүрний засаглал мөдхөн унах ёстой /түүний энэ таамаглал хожмоо батлагджээ зохиогч/ гэсэн дүгнэлтэд хүрчээ. Цааш нь тэрбээр сэтгэхдээ, Энэтхэгийн зүгээс Азийн түлхүүр нь төвд байгааг хэрвээ Англичууд төвдийг эзлэн авбал тэд нар Хөхнуур, Алаша Монголыг нөлөөндөө авах бөгөөд нэг талаар энэ нь манай Туркестан, нөгөө талаар Манжуурт нөлөөлж буддынхан тэр аяараа Оросын эсрэг босох болно. Энэ болон бусад олон санаагаа тэрбээр Дорно дахинд явуулж буй Оросын улс төрийн бодлогын тухай тэмдэглэлд өгүүлжээ. Тэнд маш олон санал, түүний дотор Хар мөрөн /Амур/-ны орчмын хязгаар нутгийг өөрчлөн байгуулах тухай ч оржээ. Тэмдэглэлийг 1893 он гээд, хааны зөвлөгч П.Бадмаев гарын үсгээ зуржээ. Тэмдэглэлд III Александрын буян үйлдсэн тогтоол гарч, түүнд: “Хэрэгжүүлэх боломжид нь үнэмшихэд бэрхтэй ч энэ бүх цоо шинэ, маш сонин санаа” гэжээ.

Мөдхөн П.А.Бадмаев төрийн 5-р зэргийн зөвлөх генерал цол хүртжээ. 1894 онд III Александрыг нас барсаны хойно өвөг эцэг чөлөөнд гарч өөрийгөө зөвхөн төвдийн анагаах ухаанд зориулжээ. Түүний хувийн амьдрал цааш хэрхэн өрнөсөн бэ? Бүр 1877 онд тэрбээр тайж язгууртан Н.Васальевнатай суужээ. Ингээд хувийн эмнэлэг эрхэлж үлэмжхэн орлого олжээ.

Петербург П.А.Бадмаевыг аль хэдийнээ эмчийн нь хувьд өргөн олноороо мэдэх болжээ. Энэ талаар Брокгауз 1891 онд хэвлэгдсэн, 8 боть нэвтэрхий толиндoo түүний тухай өгүүлсэн өгүүлэл нь нотолно. IV ботид нь Бадмаевынхны тухай өгүүлэхдээ: “Бадмаевынхан болох ах дүү хоёр буриад А.А.Бадмаев 60-аад онд Санктпетербургийн их сургуульд халимаг хэлний багш, бага дүү П.А.Бадмаев нь ахынхаа шавь, 1849 онд төрсөн. Анагаах ухааны Мэс заслийн академи төгсч практик

эмчилгээний эрх олж авчээ. Тэрбээр бүх өвчнийг онцгой аргаар өөрийн эмээр, тэрчилэн ургамлаар анагаамуй. Эмч нар түүнийг гадуурхан шоолох боловч Бадмаев руу асар олон өвчтөн ирнэ” гэж бичжээ.

Сайны хажуугаар саар гэгчээр мэргэжил нэгтнүүдийн нь атаа жөтөө, Төвдийн анагаах ухааныг эсэргүүцэгчид гарч ирлээ. Европын анагаах ухааны арга барилтай хүмүүс өвсөөр эмчлэх гэгчийг эсэргүүцдэг байв. Азийн хэлтэст Петр Александровичийг өөрийг нь хашиж асан алба түүний хэргэм цол байр суурийг нь хүчтэй болгосон гэж би бодном. Эгэл бор хар хүн луйварын эмчилгээ гэдэгт хялбархан яллуулан шийтгэгдэж байв.

Энэхүү дайралтад өвөө маань “Төвдийн /1913-1915 онд 2 удаа хэвлэгдсэн/ анагаахуй ухааны руу анагаах ухааны зөвлөлийн гишүүдийн хийсэн үндэслэлгүй дайралтад өгөх хариу” гэсэн хурц маргааны товхимлоороо хариу өгчээ. Тэр товхимолд бичихдээ “Надаар өвчтэй олон арван мянган хүн эмчлүүлсэн. Эдгээр өвчтөнүүд над дээр ирэхдээ Европын эмч нарын янз бүрийн оноштой байсан. Нэг нь ходоодны салст өвчин гэж оношилсон бол нөгөө нь ходоодны шарх, цөсний чулуу, сүрьеэ гэж янз бүрээр оношилсон байв. Төвдийн анагаах ухааны системээр өвчнийг шинжлэн тогтоож, эмчилсэн арга нь шинжлэх ухааны хатуу хөрс сууринд хийгдсэн” гэжээ.

Тэрбээр өөрийг нь шүүмжлэгчдээс “Жирийн ард түмэн яагаад энэ эмчилгээг зөв зүйтэй эмчилгээ гэж нэрлэж, төвдийн анагаах ухааны эмнэлгийг хүлээн авахад үй олноороо ирж, өдөр бүр хэдэн зуун хүн 2-3 цаг дугаарлан хүлээж, сүүлчийнхээ зоосыг барьж байна бэ? Баячууд ч ялгаагүй 5-10-25 рубль өгч байна вэ? Тэд нар гэртээ ондоо эмч залаад зүгээр суухгүй яагаад чухам төвдийн эмнэлэгт хандаж байна вэ?” гэж асууж байв.

Энд эмчилгээний үнэ хөлсний талаар харьцангуй тайлбарлах хэрэгтэй. Дээр дурьдсан мөнгө бол тухайн үедээ боломжийн хөлс байжээ. Гол нь эм үнэтэй байжээ. Эм тан, эмийн ургамал, модны үндэсний ихэнхийг Буриад, Монголоос авч ирүүлдэг байжээ. Ядуу хүн үүнийг худалдан авах нь бага байв. Миний эмэг эхийн батлан хэлснээр бол, өвөө ноорхой хувцастай ядуу хүнийг хараад түүнд хандан: “Мөнгөө далд хий, дараа болох буй заа” гэдэг байжээ. Ингээд үнэгүйгээр эм өгдөг байв. Харин саятан Мантаншев эмчид нэг үзүүлдэд л 25 рубль хаядаг байсан гэнэ.

Өөрийн номын оршлын хариудаа Бадмаев бичихдээ: “Шинжлэх ухаан болон түүний үзэл санааны нэрийн өмнөөс би Анагаах ухааны зөвлөлийн гишүүдэд хариулж байна. Ертөнцийн ариун өвийн өмнөөс эдгээрийг хүн ардаа даамжуулах үүрэгтэй гэж үзэж байна” гэжээ.

Гэлээ ч европын анагаах ухааны академийн хүрээлэнд өвөө өөрийнхөө дэмжигчдийг олжээ. “Медицина” сонины 1899 оны №1-д Юрьевын их сургуулийн анагаах ухааны факультетийн профессор, дараа нь Академич С.М.Васильев нар түүнийг дэмжин өгүүлэл нийтлүүлжээ.

“П.А.Бадмаевын төвдийн анагаах ухааны системийн тухай” гэсэн тэр өгүүлэлд: Европын анагаах ухаантай Төвдийн анагаах ухаан холбоотойг тодорхойлж, А.П.Бадмаевын орчуулсан “Жүд ши” номонд гойд анхаарсан байжээ. 1900 оны эхээр Оросын армийн Кавказын штабын ахмадын ууган охин Елизавета Федеровна Юзбашева П.А.Бадмаевын нарийн бичгийн дарга болов. 1903 оноос Елизавета Федеровна Тахилт уулан дахь /Поклонная гора/ Бадмаевын нэрэмжит төвд эмийн ургамлын эмийн сангийн эрхлэгч болжээ. 1905 онд Е.Ф.Юзбашева Бадмаевын гэргий болжээ. Елизавета Федеровна Петр Александровичийн юугаар ч сольшгүй туслагч болж, түүний номуудыг редакторлож, 300 орчим эмийг судлав. П.Александровичийг эзгүй хойгуур тэрбээр өвчтөн хүлээн авна. П.Александрович хөрөнгө хогшилоо Елизавета Федеровнад гэрээслэжээ. Бадмаевтай эн зэрэгцэх эмч байсангүй. Өвчтөнийг анагаахуй нь зүгээр нэг зөв онош тавихад гол нь биш байв. Миний эмээгийн гэрчилж буйгаар өвчтөнийг хүлээн авахдаа өвөө: “Түр азнагтун би эхлээд таны шаналгааг тодорхойлохыг оролдоё. Хэрвээ би буруу хэлбэл та залруулагтун” гэж хэлээд өвчтөний нүдийг үзэж, судасыг нь барьж үзнэ. Өвчтөн түүний тавьсан оношид шууд л итгэнэ. Тийм байдлаар Бадмаев ямар ч шинжилгээгүйгээр /цус шээсний гэх мэт/ оношийг тодорхойлно. Энд гол нь эмчилгээний зөн совингийн туршлага гэж байна. Гэвч бас үзлэгээр бодит мэдээллүүдийг олж мэднэ. Үүнд арьсны өнгө, дуу хоолой хамгийн чухал эцэст нь судас. Төвдийн анагаах ухаанд “судас оношилгоо” гэсэн нэр томъёо хүртэл буй. Хэрвээ дээрхи мэдээлэл өвчнийг тодорхойлохгүй байвал өвчтөнтэй асууж ярилцана. Юу өвдөж гэх бус хоол идсэний дараа таны бие ямар байдаг, өглөөгүүр аманд юу амтагддаг гэх мэт. Петр Александрович нэг өвчтөнийг үзэхдээ ихээхэн хугацаа зарцуулж оношийг тогтооно. Тэгээд ч тэрбээр томоохон онош тогтоогч гэгддэг байв.

Оношийг ийнхүү алдалгүй тогтоох чадвар түүний охин А.П.Гусевад уламжлан дамжсан нь гайхалтай. Тэрбээр мэс засалч эмч, дүүргийн эмнэлэгт ажилладаг байв. Тэрээр онош тавих талаараа алдаршжээ.

Хотын эрүүлийг хамгаалах газраас өвчтөнүүдийг илгээж зөвлөгөө авдаг байлаа. Нэг удаа өвчтөн: “Гусева надад шинжилгээ хийлгүй оношиллоо” гэж гомдолложээ. Өвчтөнийг клиник эмнэлэгт 3 хоног байлгаж шинжилгээ хийхэд Гусевагийн онош батлагджээ. Үл итгэсэн өвчтөн эмчид ирж уучлал гуйжээ.

Ерөөс европ, төвдийн анагаах ухаан ганц л зорилготой. Тэр нь юугэвэл өвчтөнд туслах, анагаах аргыг тодорхойлох, өвчнийг оношлох

явдал болой. Өвчтөнийг эмч чагнаж, тэмтэрч үзээд шинжилгээ, рентген гэх мэт рүү явуулдаг нь оношилгооны уламжлалт арга юм.

2-р арга бол төвдийн анагаах ухаанд эрхэмлэдэг асуулт хариулт, судас барих арга юм. Хэрвээ европ эмч олгойны үрэвсэл, элэгний томрол, хорт хавдар гээд л хэлчихдэг. Тэгвэл төвд эмч өвчнийг бүр 2 жилийн өмнө хэлж чаддаг нь урьдчилан сэргийлэх арга болдог.

Туршлагатай авъяаслаг эмчийн хувьд өвчтөний арьс нүдний байдал, дуу, судасыг үзэх нь чухалыг энд давтан хэлсү. Төвдийн эм тан ямар ч харшилгүй, аль нэг дагалдах үр дагаваргүйгээр ялгаатай, химийн бодис байдаггүй, голдуу өвс ургамал байдаг. Тэдгээр нь Агийн тал, Монгол, Төвдөд ургана. Модны үндэс, эрдэс бодис ч буй. Ийм эм нян янг үүсгэх бус, харин бие махбодод өөрөө нян янтай тэмцэх чадвартай болгоно. Алим, нэг аяга буцалгасан цэвэр ус гэх мэт.

Түүний нэр алдар өсөхийн хэрээр Бадмаевыг ордонд урьж, хаад ноёд, хатагтай нарт үйлчилүүлдэг байжээ. Түүнтэй II Николай хаан ч нүүр учирдаг байв. Бадмаев түүнийг залуудаа мэддэг байжээ. Тийм болохоор түүнтэй захиагаар харьцах бололцоотой гэж үздэг байв. Тухайлбал, тэрээр нүүдлийн аж төрөх ёсоо эрхэмлэхэд нь Буриадуудад шахалт дарамт үзүүлж буйд гомдолсон захидал хаан болон дотоод яамны сайд Плеве нарт илгээж байжээ. Өвөө буриадуудыг Агийн талд нутаглах эрхийн нь төлөө тэмцдэг байжээ. Тэгээд ч Плеве түүнийг Архангельск рүү цөлнө гэж заналхийлж байв. Бадмаевын нарийн бичгийн дарга Е.И.Вишневскийн гэрчилж буйгаар Петр Александрович энэ заналхийлэлийн хариу болгож сайдад “Архангельск явах ямар падтай юм. Явбал явна. Тэгэхдээ таньтай цуг явна” гэж захиа бичиж байжээ. Ер нь таньдаг талархдаг хүмүүсийн нь өгүүлсэнээр п.А.Бадмаев маш их зүрх зоригтой хүн байжээ.

1917 онд тэрбээр Большевикуудын талд бус хэмжээгүй эрхт эзэнт хааны үзэлдээ үнэнчээр үлджээ. Үүнийгээ ч нуудаггүй байсан тул түүнийг олон удаа баривчлан шоронд суулгажээ. Тэрхүү догшин хэрцгий цаг үед монархистууд, урьдын генералууд түүнийг буудаж чадах л байлаа. Гэвч өвчтөнүүд түүнд орлого оруулж байсан ба түүний дунд большевикууд ОСДН-ын гишүүд ч байлаа. Түүнийг шоронгоос сулласаны дараа олон усан цэрэг гэрт нь ирж үзүүлж байсан нэг содон тохиол байдаг. Шинэ засагтай эвлэрэхэд түүнд бэрхтэй байсан аж. Олон арван жил ийм байдлаар аж төржээ. Урьдын хааны засгийн газартай тэрбээр сөргөлдөв. 1916 онд Дотоод хэргийн сайд А.Д.Протоновыг өөрийнхөө гэрээс хөөв. Гэвч дараа өдөр нь Петр Александровичийн хүсэлтээр Елизавета Федеровна Александр хаанаас өршөөл гуйхаар явжээ. Энэ талаар Бадмаев хэлэхдээ: “Миний сувилуулагчаас уучлал

гуйгаарай. Дахиад ч ирж болно. Сайдыг би зэмлэж чадах авч өвчтөнийг тэгэх эрхгүй” /хаан нэг талаар түүний өвчтөн байжээ/.

Протонов удамшилын хүнд өвчтэй байсан учраас европын эмч нар үзэхээсээ татгалздаг байжээ. 1919 онд өвөг эцэг хорих газарт хоригдож байхдаа лагерын комендатыг алгадаж түүний “п” хэмээн буруу харьцжээ. Комендат өвөөг 2 хоног мөглөн буюу ууганд хийжээ. Үүний дараа Петр Александрович анх удаа гэдэсний хижигээр өвджээ. Ингээд шоронгийн тусгаарласан хориход хүргэгджээ. Тэр үед энэ өвчин хорих газар их дэлгэрч байв. Харин эмэг эхэд маань өвөөгийн дэргэд асарч байх зөвшөөрөл өгчээ.

Шорон гяндан, байцаалтаас сэтгэл нь хямарсанаас Петр Александровичийн төмөр мэт эрүүл чийрэг бие махбодь нэн буснижээ. Тэрбээр энэ бүх зовлонгоос хялбархан ангижирчих байв. Тухайлбал, сонин хэвлэлээр шинэ засгаас уучлал гуйх, Японы элчин сайд түүнд Японд гэр бүлтэйгээ саадгүй явах баталгаа санал болгож байжээ. Гэвч Петр Александрович хүнд бэрх цагт Оросыгоо хаяхыг хүссэнгүй. Харин сэтгэлээр унаж зовлон зүдгүүр ханатлаа амсжээ.

Тэрээр өөрт нь үлдээсэн жижиг 5 өрөөтэй байрандаа гэрийнхэнийхээ хүрээлэлд нас баржээ. 1920 оны 8-р сарын 1-ны халуун өдөр өвөөг Шувеловскийн оршуулгын газарт оршуулжээ. Петр Александрович нас барахынхаа өмнө эхнэртээ өөрийгөө үхсэний хойно өвчтөнг хүлээн авахаа таслалгүй, үйл хэргийг нь үргэлжлүүлэх ам авчээ. Е.Ф.Бадмаева нөхрийнхөө гэрээсийг биелүүлэв. 1920-1937 он хүртэл тэрбээр эрүүл мэндийн хэлтэст тусгай зөвшөөрлөөр өвөөгийн кабинетэд өвчтөн хүлээн авсаар байжээ.

Би өвөөгийнхөө нас барсан тэр газар болох Тахилгат уулнаас холгүй орших эмэг эхийн гэрт өссөн. Тэр байшин бол тоосгон өндөр суурьтай, төмөр дээвэртэй, модон байшин байж билээ. Дэргэд цөөрөм бүхий цэцэрлэгтэй. Энэхүү голт борын цэцэрлэгт миний бага нас өнгөрсөн юм. 1937 он хүртэл онцгой хүндрэл гарсангүй. Харин эмээг Дотоод хэргийн Яам Ардын Комисиратийн газраас 2 удаа дуудаж, “Бадмаевын алтыг” эргүүлж өгөхийг шаарджээ. Ингээд эмэг эх алтан бугуйвчаа тайлан өгч ондоо зүйлсийг хувьсгал хураасан гэж мэдэгджээ. Бугуйвчний нь оронд түүнд хураасан гэсэн цоохор цаас л үлдээжээ.

Гал түймрийнхэн манайд ирж гал унтраагч өгсөн. Учир нь манай байрны дээврийн том хөндий тэр аяараа эмийн ургамалаар дүүрэн байлаа. Зун нь манайд буриадууд, монголчууд эмийн ургамал, эрдэс нийлүүлнэ. 1935 онд ээж Ленинградын анагаах ухааны 2-р институт төгсөж эмчийн диплом авлаа. Ээж Төвдийн анагаах ухаан мэддэг байсан ч мэс заслын мэргэжил сонгосон юм. Ийнхүү бид 1937 он хүртэл аж төрөв. Харин дараа нь тэр үеийн айл бүрд тулгарч байсан хэргээр эмээг маань



баривчлан 8 жилийн хорих ялаар шийтгэв. Тэр үед тэрбээр 68 настай байв. Түүнийг Каракалнакын гулагт илгээж тэндээ 2 жил болов.

1940 оны эхээр ээж Е.Ф.Бадмаевын хэргийг сөхөж үзэхэд хүрлээ. Түүнийг чөлөөлж хаана ч аж төрөх эрх өгөв. Ер нь 1953 он хүртэл зөвлөлт эх орондоо амьдарлаа ч бүр орондоо ороод ногоон хувцастанууд шөнө ирэх юм биш биз гэж түгшдэг байв.

1930-аад онуудад эмэг эх ням гараг бүр Шувалевскийн оршуулгын газар очих ба хааяа намайг авч явна. Бид Петр Александровичоор эмчлүүлж асан хүмүүсээс шинэ цэцэг авч булшин дээр тавьдагсан. Дайны дараа би эмээгээ асарч хааяа өвөөгийн булш дээр очдог ч цэцэг олдохоо болив. Өвөөгөөр эмчлүүлэгчид дайнд явжээ. Елизавета Федеровна Бадмаева 1954 онд 82 насандаа таалал төгссөн.

1990 оны 4 сарын эхээр П.А.Бадмаевын эмчилгээний сургуулийг сэргээх түүний бүтээлүүдийг хэвлэх зорилготой Петр Бадмаевын төвдийн анагаах ухааны шинжилгээ судалгааны төв байгуулагдав. Түүнээс гадна “Жүд ши”-гийн орчуулгаас гадна тэрбээр Төвдийн анагаах ухааныг сурталчилсан олон ном бичсэн юм. Жишээлбэл “Орос ба Хятад”, “Төвдийн анагаах ухаан”, “Анагаах ухааны зөвлөлийн гишүүдээс хийсэн үндэсгүй дайралтуудад өгөх хариу” гэх мэт. Эдгээр бүтээлүүд өнөөдөр ч чухал ач холбогдолтой хэвээр байна. П.А.Бадмаевын нэр сүрийг олон жилийн турш эрдэмтэдийн анхаарлыг ихэд татсан өвчинд шаналсан олон хүмүүс түүнийг дуссаар байна.

Петр Бадмаевын үйл хэрэг үргэлжилсээр байна.

*С.Гусев. “Төвдийн анагаах ухааны нууц”. М.1997*

*Орос хэлнээс товчлон орчуулсан:  
Л.Бэгзжав, Т.Даваа,*